



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/191

Мандалговь

Төрийн байгууллагуудын ажлын
цагийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "л", 30 дугаар зүйлийн 30.1.17 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, дулааны улирал эхэлж байгаатай холбогдуулан аймаг, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын ажлын цагийг 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл үдээс өмнө 08:00-12:30, үдийн цайны цаг 12:30-13:30, үдээс хойш 13:30-17:00 цаг болгон өөрчилсүгэй

Хоёр. Энэхүү захирамжийг иргэд, олон нийтэд сурталчилж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат)-д, сумдын Засаг дарга, аймгийн төрийн байгууллагуудын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210520